



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/438

Ховд


Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоол, Сангийн сайдын 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чөлөөлөх дайны ялалтын ойг жил бүрийн 8 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас шийдвэрлэсэн бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын байдлын баталгаа болсон Чөлөөлөх дайны 75 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Ховд аймгийн Үенч суманд оршин суугаа 1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Естэйн Магнайд олгох нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1 000 000 төгрөг/ нэг сая/-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 1 000 000 төгрөг /нэг сая/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны
08 дугаар сарын 14-ний өдрийн
А/438 дугаар захирамжийн хавсралт



АХМАД ДАЙЧИНД НЭГ УДААГИЙН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЗАРДАЛ

№	Овог нэр	Харьяалал	Мөнгөн дүн
1.	Естэйн Магнай	Үенч сумын өндөр настан, ахмад дайчин	1 000 000
Дүн			1 000 000

-оОо-